



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/056/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Нямбуу

Утас: 70453799

Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ШИЖИРБОЛД ТАНАА

2026.02.05 № УВА - 2025/056/НА - СТА - ТШЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолыг үндэслэн Увс аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/703 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны газрыг 9 орон тоотойгоор шинээр байгуулсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,515,900.00</u>	<u>1,741,276.00</u>
33	Авлага	<u>0.00</u>	<u>295,026.00</u>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	<u>0.00</u>	<u>292,026.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,515,900.00	1,446,250.00
354	Хангамжийн материал	1,515,900.00	1,446,250.00
35410	Бичиг хэргийн материал	895,000.00	267,150.00
35470	Бусад хангамжийн материал	620,900.00	1,179,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,725,262.07</u>	<u>28,064,859.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,725,262.07	28,064,859.90
392	Биет хөрөнгө	26,377,512.07	26,259,304.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,000,000.00)	(40,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,900,406.43	30,396,251.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,245,966.62)	(8,662,042.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,029,883.05	6,029,883.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(306,810.79)	(1,504,787.47)
393	Биет бус хөрөнгө	1,347,750.00	1,805,555.60
39301	Програм хангамж	1,695,000.00	2,875,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(347,250.00)	(1,069,444.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>29,241,162.07</u>	<u>29,806,135.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>773,200.00</u>	<u>715,337.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	773,200.00	715,337.00
413	Өглөг	773,200.00	715,337.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	715,337.00
4136	Бусад өглөг	773,200.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	773,200.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>28,467,962.07</u>	<u>29,090,798.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	28,467,962.07	29,090,798.90

512	Хуримтлагдсан үр дүн	28,467,962.07	29,090,798.90
51210	Өмнөх үеийн үр дүн	28,467,962.07	28,467,962.07
5122	Тайлант үеийн үр дүн	0.00	622,836.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	29,241,162.07	29,806,135.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	427,249,189.48	483,290,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,748.889.48	3,780,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,748,889.48	3,780,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,350,000.00	3,780,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,350,000.00	3,780,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	47,398,889.48	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,500,300.00	479,510,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,500,300.00	477,510,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,500,300.00	477,510,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	398,781,227.41	481,225,420.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,781,227.41	481,225,420.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,211,319.79	454,306,466.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,217,287.00	356,392,865.50
210101	Үндсэн цалин	217,217,287.00	178,655,305.00
210102	Нэмэгдэл	0.00	136,767,958.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	15,289,005.00
210104	Урамшуулал	0.00	25,680,597.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,782,278.78	44,628,261.68
210201	Тэтгэврийн даатгал	18,744,169.43	30,338,361.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,943,418.87	3,572,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,088,820.47	1,786,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,173.93	1,786,200.00

210205	Эрүүл мэндийн даатгал	3,204,696.08	7,145,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,800,000.00	1,800,000.00
210304	Байрны түрээс	1,800,000.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,952,266.60	19,271,700.00
210401	Бичиг хэрэг	2,099,800.00	1,539,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,850,200.00	14,472,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,671,566.60	1,827,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,330,700.00	1,432,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,693,000.00	8,433,000.00
210604	Урсгал засвар	7,693,000.00	8,433,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,661,800.00	10,396,800.00
210702	Дотоод албан томилолт	5,661,800.00	10,396,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,458,660.00	3,595,379.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,542,360.00	2,961,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,500.00	97,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,800.00	190,479.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	648,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,646,027.41	9,788,459.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,746,000.00	250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,900,027.41	9,538,459.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,569,907.62	26,918,954.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,692,584.00	8,029,499.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,216,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,676,784.00	7,629,499.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,799,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,877,323.62	18,889,454.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,877,323.62	18,889,454.84
3	Үйл ажиллагааны үр дүн (3)=(1)-(2)	28,467,962.07	2,064,779.09
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	0.00	1,441,942.26
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	0.00	1,441,942.26

4	Үйл ажиллагааны бус үр дүн (4)=(145-225)		(1.441.942.26)
5	Нийт үр дүн (5)=(3)+(4)	28,467,962.07	622,836.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	379,850,300.00	483,290,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,350,000.00	3,780,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,350,000.00	3,780,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,350,000.00	3,780,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,350,000.00	3,780,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,500,300.00	479,510,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,500,300.00	477,510,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,500,300.00	477,510,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	355,623,900.00	471,970,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,623,900.00	471,970,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,053,992.38	443,651,245.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216,444,087.00	357,095,016.18
210101	Үндсэн цалин	121,634,341.00	178,655,305.00
210102	Нэмэгдэл	78,979,726.00	136,767,958.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,264,180.00	16,062,205.00
210104	Урамшуулал	11,565,840.00	25,609,548.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,782,278.78	44,279,000.00
210201	Тэтгэврийн даатгал	18,509,947.43	29,989,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,640.87	3,572,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,088,820.47	1,786,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	801,173.93	1,786,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,204,696.08	7,145,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,800,000.00	1,800,000.00

210304	Байрны түрээс	1,800,000.00	1,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,078,166.60	18,492,050.00
210401	Бичиг хэрэг	2,919,500.00	843,450.00
210402	Тээвэр, шатахуун	3,850,200.00	14,472,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,641,866.60	1,717,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,666,600.00	1,458,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,913,000.00	8,433,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	220,000.00	0.00
210604	Урсгал засвар	7,693,000.00	8,433,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,661,800.00	8,936,800.00
210702	Дотоод албан томилолт	5,661,800.00	8,936,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,628,660.00	4,305,379.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,652,360.00	3,071,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,500.00	97,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,800.00	190,479.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	708,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,746,000.00	310,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,746,000.00	310,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,569,907.62	28,318,954.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,692,584.00	9,429,499.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,216,800.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,676,784.00	7,629,499.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,799,000.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,877,323.62	18,889,454.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,877,323.62	18,889,454.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,226,400.00	11,320,000.00
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5)	24,226,400.00	11,320,000.00
	Дотоод эх үүсвэрээр	24,226,400.00	11,320,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,226,400.00	11,320,000.00
5	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5)	(24,226,400.00)	(11,320,000.00 9)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	28,467,962.07	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	28467962.07		28467962.07
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	622,836.83	00.00	622,836.83
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,090,798.90	00.00	29,090,798.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,510,200.00	462,400,745.16	20,109,454.84	95.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,510,200.00	462,400,745.16	20,109,454.84	95.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,590,200.00	452,971,245.18	19,618,954.82	95.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,248,300.00	357,095,016.18	153,283.82	99.9%
210101	Үндсэн цалин	159,289,000.00	178,655,305.00	19,366,305.00	112.1%

210102	Нэмэгдэл	171,365,900.00	136,767,958.00	34,597,942.00	79.5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,274,400.00	16,062,205.00	-1,787,805.00	112.5%
210104	Урамшуулал	12,319,000.00	25,609,548.18	13,290,548.18	207.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,279,000.00	44,279,000.00	0.00	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	19,135,800.00	18,509,947.43	0.00	100.0%
210202	Тэтгэмжийн даатгал	2,087,100.00	2,177,640.87	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,043,500.00	1,088,820.47	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,043,500.00	801,173.93	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,440,000.00	3,204,696.08	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,800,000.00	1,800,000.00	00.00	100.0%
210304	Байрны түрээс	1,800,000.00	1,800,000.00	00.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	17,040,900.00	16,492,050.00	548,850.00	96.7%
210401	Бичиг хэрэг	1,003,000.00	843,450.00	159,550.00	84.0%
210402	Тээвэр, шатахуун	11,685,000.00	12,472,800.00	-787,800.00	106.7%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,233,500.00	1,717,300.0	1,516,200.00	53.1%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,119,400.00	1,458,500.00	-339,100.00	130.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,241,000.00	17,253,000.00	3,988,000.00	81.2%
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,801,000.00	8,820,000.00	1,981,000.00	74.7%
210604	Урсгал засвар	9,440,000.00	8,433,000.00	1,007,000.00	89.3%
2107	Томилолт, зочны зардал	22,303,600.00	8,936,800.00	13,366,800.00	40.0%
210702	Дотоод албан томилолт	22,303,600.00	8,936,800.00	13,366,800.00	40.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,228,600.00	6,805,379.00	1,423,221.00	82.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,421,900.00	3,071,900.00	1,350,000.00	69.4%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00		100%
210803	Даатгалын үйлчилгээ	97,000.00	97,000.00	00.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,000.00	190,479.00	521.00	99.7%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,000.00	11,000.00	66.6%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,161,700.00	3,100,000.00	61,700.00	98.5%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	448,800.00	310,000.00	138,800.00	69.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	448,800.00	310,000.00	138,800.00	69.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,920,000.00	9,429,499.98	490,500.02	95.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,920,000.00	9,429,499.98	490,500.02	95.0%
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,920,000.00	7,629,499.98	290,500.02	96.3%

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,800,000.00	200,000.00	90.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	482,510,200.00	462,400,745.16	20,109,454.84	95.0%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	477,510,200.00	458,620,745.16	18,899,454.84	96.5%
132001	Орон нутгийн төсвөөс	477,510,200.00	458,620,745.16	18,899,454.84	96.5%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	3,780,000.00	1,220,000.00	75.6%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	3,780,000.00	1,220,000.00	75.6%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	10.50	01.00	87.5%
620001	Удирдах ажилтан	01.00	0.50	0.50	50.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	07.00	01.00	87.5%
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	00.00	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2,000,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,000,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,000,000.00	
210402	Тээвэр, шатахуун	0.00	2,000,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	2,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулах үйл ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэгч байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 564.9 мянган төгрөгөөр буюу 1.93 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	295.0	295.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	1,515.9	1,446.2	-69.7
Үндсэн хөрөнгө	27,725.3	28,064.9	339.6
Нийт хөрөнгө	29,241.2	29,806.1	564.9
Өр төлбөр	773.2	715.3	-57.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	28,468.0	29,090.8	622.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,241.2	29,806.1	564.9

Авлагын данс 295.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69.7 мянган төгрөг болж буурсан нь аж ахуйн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 339.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,320.0 мянган төгрөгөөр хөрөнгө авсан, тайлант онд 9,538.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 2,749.4 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, 894.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн, дансны хасалт 2,202.2 мянган төгрөгийн хөрөнгийн хасалттай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 715.3 мянган төгрөг нь ажилтанд өгөх өглөг буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 564.9 мянган төгрөг болж өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 445,519.3 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөг нийт зарлагыг 450,519.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 85,068.9 мянган төгрөгөөр өсгөж орон нутгийн төсвөөс 530,588.2 мянга, үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянга, нийт 535,588.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2025 оны 09 дүгээр сард 53,078.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 477,510.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 458,620.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 2,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,780.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 462,400.7 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь төлөвлөснөөс үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 17,155.8 мянга, мэдээлэл сурталчилгааны зардлын төсвийг 455.0 мянга, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлын төсвийг 788.1 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг зардлын төсвийг 490.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70418-80101 Худалдан авах ажиллагаа- Үндсэн үйл ажиллагаан зардал	482,510.2	462,400.7	20,109.5	95.8%
2	70418-80111 Худалдан авах ажиллагаа- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	7,100.0	7,100.0	0	100%
3	70418-80205 Худалдан авах ажиллагаа- Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,365.0	1,365.0	0.0	100%
4	70418-80224 Худалдан авах ажиллагаа- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	1,750.0	961.9	788.1	54.9%
5	70418-80802 Худалдан авах ажиллагаа- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	9,920.0	9,429.5	490.5	95.0%

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	16,062.2	2025 онд нэг өдрийн хоолны зардал 6,8 мянган төгрөгөөр тооцож жилийн 16,062.2 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
2	Гадаад томилолт, арга хэмжээ	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
3	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
4	Программ хангамж	2,875.0	CTSystem 6.5, Estimator pro программ ашигладаг.
5	Сургалт, семинар	-	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал гараагүй байна.

6	Орон тооны цомхотгол	-	Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2025 онд 12 орон тоо ажиллахаар батлагдсанаас 10.5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	2,000.0	Тендерийн урилгыг зар мэдээгээр мэдээлж олон нийтэд хүргэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөв буюу байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,000.0 мянган төгрөгөөр бүрдүүлжээ. Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 2,000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь тендер шалгаруулалт зохион байгуулаагүй ч шууд худалдан авалтаар 25,797.7 мянган төгрөгийн бараа материал, 8,820.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,500.0 мянган төгрөгийн программ тус тус худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 398,781.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,987.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,190.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 481,225.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,812.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,849.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Худалдан авах ажиллагааны газар нь шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2,200.0 мянган төгрөгийн 2 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн 6 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161, мэдээлэх хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож оруулсан 6, мэдээлээгүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 052 дугаар албан бичгээр Увс аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.НЯМБУУ/

2026 оны 01 сарын 30-ны өдөр